

| | |
|---|-----|
| ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ | i |
| ОРШИЛ..... | ii |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ | iv |
| ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА | 1 |
| 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл..... | 1 |
| 1.1.1 Төслийн нэр: | 1 |
| 1.1.2 Төсөл хэрэгжүүлэгч: | 1 |
| 1.1.3 Төслийн талбайн байршил, хэрэгжих орчны тойм зураг..... | 1 |
| 1.2 Хотхоны төлөвлөлт | 3 |
| 1.3 Хүчин чадал, багтаамж | 2-1 |
| 1.4 Цэвэрлэх байгууламж | 2-1 |
| 1.5 Дэд бүтэц..... | 2-1 |
| 1.6 Хог хаягдал | 2-2 |
| ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН | |
| ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ | 2-3 |
| 2.1 Физик газарзүй | 2-3 |
| 2.2 Уур амьсгал..... | 2-3 |
| 2.3 Гадаргын ус..... | 2-3 |
| 2.4 Хөрсөн бүрхэвч | 2-3 |
| 2.5 Ургамлан нөмрөг | 2-4 |
| 2.6 Амьтны аймаг | 2-4 |
| 2.7 Нийгэм-Эдийн засаг | 2-4 |
| ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛлийн товч тодорхойлолт | 3-5 |
| БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ | |
| 4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 9 |
| 4.2 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө | 13 |
| 4.3 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | 13 |
| 4.4 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө..... | 14 |
| 4.5 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 16 |
| 4.6 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 19 |
| 4.7 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ | 20 |
| 4.8 2021 оны БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө..... | 21 |
| Хавсралтын жагсаалт | a |
| ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ | |
| Хүснэгт 1. Дагаж мөрдөх хууль | iv |
| Хүснэгт 2. Дагаж мөрдөх стандартууд..... | v |
| Хүснэгт 3. Дагаж мөрдөх Байгаль орчны дүрэм, журам | vi |
| Хүснэгт 4. Төслийн талбайн солбицол, WGS-84 /UTM-48N/..... | 1 |
| Хүснэгт 5. Ажилчдын хотхоны ажиллах хүчний үзүүлэлт | 2-1 |
| Хүснэгт 6. Шингэн хаягдлын тооцоо | 2-2 |
| Хүснэгт 3-1. Хүнд даацын автомашины ээлж солилцох зогсоолын талбай төслийн байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл | 3-5 |
| Хүснэгт 4-1. БОМТ-г хэрэгжүүлэх зардал, 2022 он..... | 4-8 |
| Хүснэгт 4-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 9 |
| Хүснэгт 3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 15 |
| Хүснэгт 4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр..... | 17 |
| Хүснэгт 5. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 19 |
| Хүснэгт 6. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, 5 жилээр .. | 20 |
| Хүснэгт 7. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь | 21 |

ОРШИЛ

“Цагаан дэлгэрэх өргөө” ХХК нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон багийн нутагт “Ажилчдын хотхон, авто зогсоол байгуулах” төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Манай компани Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх “Ажилчдын хотхон, авто зогсоол байгуулах” төслийн талбай, түүний орчны байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолтыг Байгаль орчны судалгаа, үнэлгээний “Трийнтрэндс” ХХК-иар захиалгаар хийж гүйцэтгэсэн.

Төслийн БОМТ-ний тайланг Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”, 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” заасны дагуу хийж гүйцэтгэлээ.

“Ажилчдын хотхон, авто зогсоол байгуулах” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоож, тэдгээр сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ, болзошгүй эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ зэргийг боловсруулан, цаашид “Цагаан дэлгэрэх өргөө” ХХК-ийн байгаль орчныг хамгаалах талаар 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан, холбогдох зардлуудыг тусгав.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ

Энэ бүлэгт уг төслийг хэрэгжүүлэх явцад мөрдвөл зохих үндэсний болон олон улсын бодлого, хууль журмыг нэгтгэн оруулсан.

Төсөл хэрэгжүүлэгч “Цагаан дэлгэрэх өргөө” ХХК нь эдгээр бодлого, хууль журмыг сахин биелүүлж төслөөс учрах аливаа сөрөг нөлөөллийг Монгол улсын хууль, журам дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн хамгийн бага түвшинд, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгах үүрэгтэй. (Хүснэгт 1-ээс Хүснэгт 3-д харуулав).

| <i>Хүснэгт 1. Дагаж мөрдөх хууль</i> | |
|---|--|
| <i>Хуулийн нэр</i> | <i>Тайлбар</i> |
| <i>Байгаль орчныг хамгаалах тухай хууль</i> | 1995 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн, түүнээс хойш нийт 24 удаа нэмэлт өөрчлөлт орсон ба хамгийн сүүлд 2019 оны 11 дугаар сарын 13-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. |
| <i>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль</i> | Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль 2012 оны 5-р сарын 17-ны өдөр шинэчлэн найруулагдсан ба 2015 оны 12-р сарын 04 болон 2017 оны 02-р сарын 02-ны өдрүүдэд нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан. |
| <i>Амьтны тухай хууль</i> | 2000 оны 5-р сарын 5-аас хүчин төгөлдөр болсон, 2012 оны 5 дугаар сарын 17 өдөр шинэчлэн найруулсан. |
| <i>Байгалийн ургамлын тухай хууль</i> | 1995 оны 4-р сарын 11-ээс хүчин төгөлдөр болсон, түүнээс хойш 4 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан ба хамгийн сүүлд 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. |
| <i>Газрын тухай хууль</i> | 2002 оны 6 дугаар 7-ны өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн, одоог хүртэл нийт 30 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан. |
| <i>Газрын төлбөрийн тухай хууль</i> | 1997 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр хүчин төгөлдөр болсон, 2005, 2006, 2009, 2012 онууд болон хамгийн сүүлд 2019 онд нэмэлт өөрчлөлт орсон. |
| <i>Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль</i> | 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр хүчин төгөлдөр болсон ба 2015 оны 11, 12-р саруудад нэмэлт өөрчлөлт орсон. |

| | |
|---|---|
| Усны тухай хууль | 1995 оны 6-р сарын 5-аас хүчин төгөлдөр болсон ба 2015 онд 2 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон. |
| Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль | 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр хүчин төгөлдөр болсон ба 2015, 2017, 2019 онуудад нэмэлт өөрчлөлт орсон. |
| Агаарын тухай хууль | 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр хүчин төгөлдөр болсон ба үүнээс хойш 7 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан. |
| Агаарын бохирдлын төлбөрийн тухай | 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдөр хүчин төгөлдөр болсон ба 2012, 2015 онд 2 удаа, 2018, 2019 онуудад нийт 5 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан. |
| Хог хаягдлын тухай хууль | 2003 оны 11-р сарын 28-ны өдөр баталсан Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийг хүчингүйд тооцож, 2012 оны 5-р сарын 17-ны өдөр батлагдсан бөгөөд 2017 он шинэчлэн баталсан. |
| Соёлын өвийг хамгаалах тухай хууль | 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдөр шинэчлэн найруулагдаж 2015, 2016 онуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. |
| Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль | 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр батлагдаж үүнээс хойш будаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна. |
| Галын аюулгүй байдлын тухай хууль | Галын аюулгүй байдлын тухай хууль нь 2015 оны 7-р сарын 2-ны өдөр шинэчилсэн найруулагдаж 2015 оны 12-р сарын 04 өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. |
| Хөдөлмөрийн тухай хууль | 1999 оны 5 дугаар сарын 14-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж, өдийг хүртэл нийт 25 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна. |

| Хүснэгт 2. Дагаж мөрдөх стандартууд | | |
|-------------------------------------|--|------------------------|
| № | Стандартын нэр | Дугаар |
| 1 | Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага | MNS 4585:2016 |
| 2 | Агаарын чанар – Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ | MNS 6063:2010 |
| 3 | Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага | MNS 3113:1981 |
| 4 | Агаарын чанарын нийтлэг асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга | MNS 5365:2005 |
| 5 | Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага | MNS 5885:2008 |
| 6 | Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага | MNS 5344:2011 |
| 7 | Автомашини дизель хөдөлгүүрийг утааны тортгийн шүүлтүүр (DPF)-ээр тоноглох, ашиглах. Техникийн ерөнхий шаардлага | MNS 6757:2019 |
| 8 | Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт | MNS 5914:2008 |
| 9 | Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт | MNS 5916:2008. |
| 10 | Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага | MNS 5918:2008 |
| 11 | Байгаль орчны хамгааллын стандартын систем. Аж ахуйн нэгжийн экологийн паспорт. Үндсэн дүрэм | MNS 4219:92 |
| 12 | Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх | MNS 3297:2019 |
| 13 | Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд | MNS 3298:1991 |
| 14 | Бохир ус цэвэрлэх байгууламж. 10-р хэсэг: Аюулгүй ажиллагааны зарчмууд | MNS EN 12255-10 : 2012 |
| 15 | Галын аюулгүй байдал. Техникийн шаардлага | MNS 4244:94 |
| 16 | Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж байгууллага байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм | MNS 5566:2020 |

| | | |
|----|---|------------------------|
| 17 | Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт | MNS 5916:2008 |
| 18 | Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага | MNS 5390:2004 |
| 19 | Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт | MNS 0900:2018 |
| 20 | Ундны ус-Хуурай үлдэгдлийн хэмжээг тодорхойлох | MNS 4423:1997 |
| 21 | Ундны ус. Хатуулаг тодорхойлох арга | MNS 6778:2019 |
| 22 | Усны чанар. Хортой хүнд металл тодорхойлох Рентген флюоресценцийн арга. | MNS 5032:2001 |
| 23 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага | MNS 4968:2000 |
| 24 | Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ | MNS 5850:2019. |
| 25 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Өргөх, зөөх ачааны массын дээд хэмжээ | MNS 4970:2000 |
| 26 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Ачих буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. | MNS 5079:2001 |
| 27 | Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам | MNS 2305:1995 |
| 28 | ХААЭА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага | MNS 4990:2000 |
| 29 | Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө | MNS ISO 4227:2002 |
| 30 | Хүрээлэн байгаа орчин. Хаягдал ус. Ерөнхий шаардлага | MNS 4943:2015 |
| 31 | Авто тээврийн хэрэгслийн дуу чимээ. Дуу чимээний хүлцэх түвшин, хэмжих арга | MNS 0017-5-1-21:1992 |
| 32 | Газар шорооны ажлын машин. Хөрс ухаж тээвэрлэх. Бульдозер. Нэр томъёо ба техникийн шаардлага | MNS ISO 6747:2005 |
| 33 | Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага | MNS 4943:2015 |
| 34 | Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага | MNS 4978 : 2017 |
| 35 | Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага | MNS 4919:2000 |
| 36 | Явган хүний зам, талбайн төлөвлөлт. техникийн шаардлага | MNS 6808:2019 |
| 37 | Цэвэрлэсэн хаягдал усыг усалгаанд ашиглах гарын авлага. 4-р хэсэг: Хяналтшинжилгээ | MNS ISO 16075-4 : 2018 |

Хүснэгт 3. Дагаж мөрдөх Байгаль орчны дүрэм, журам

| № | Журам | Тайлбар |
|---|---|--|
| 1 | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам. <i>Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-03 тоот тушаалын хавсралтаар батлагдсан.</i> | Энэхүү журамд олон нийтийн оролцоог хангах шаардлагыг стратегийн, хуримтлагдах нөлөөллийн, ерөнхий ба нарийвчилсан үнэлгээ гэсэн үнэлгээний төрөл тус бүрээр зааж өгсөн байна. Эдгээрээс хамгийн чухал заалтуудын нэг нь 2.7-д заасан “Үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж нь төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж дууссаны дараа үнэлгээний тайлан, олон нийтийн саналын нэгдсэн дүнг ажлын 15 өдрийн хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны нийтийн хурлаар хэлэлцүүлж санал авна”. |
| 2 | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам. <i>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралтаар</i> | Төсөл хэрэгжүүлэгч нь тус журмын 1.6-р зүйлд зааснаар журмын 1.5-т заасан Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөж буй байгаль орчны дор дурдсан бүрдэл хэсгүүдийг заавал тусгаж, бүрдэл хэсэг тус бүрээр хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хэмжилт, дээжлэлт авах үзүүлэлт, тоо, хугацаа, давтамж, |

| | | |
|---|---|--|
| | <i>баталсан.</i> | зарцуулах зардал, хариуцан гүйцэтгэх этгээд, баримтлах стандарт, аргачлалыг нарийвчлан тусгана. |
| 3 | Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам. <i>Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан.</i> | Монгол Улсын иргэнд өмчлүүлэх болон иргэний өмчийн газар, Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах болон тэдний эзэмшиж, ашиглаж байгаа газар, гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хууль тогтоомжийн дагуу ашиглуулах болон ашиглуулж байгаа газарт, түүнчлэн өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгоогүй төрийн өмчийн бусад газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг хийхэд энэхүү журмыг баримтална. Газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газарт төлөвлөгөөт хянан баталгааг 5 жилд нэг удаа хийнэ. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулахаар газар олгох, Газрын тухай хуулийн 16.1.3-16.1.8-д зааснаар газрыг тусгай хэрэгцээнд авах болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход тухай бүр хянан баталгааг хийнэ. |
| 4 | Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам. <i>Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 тоот тушаалын хавсралтаар батлагдсан.</i> | Энэхүү журмыг ус олборлох, дамжуулах, нөөцлөх, борлуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа ус хангагч, усны тоолуурын хэмжил зүйн ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага болон ус ашиглагч, хэрэглэгч дагаж мөрдөнө. Унд, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтын усны олборлолт, дамжуулалт, нөөцлөлт, борлуулалт, хаягдал усны тоо хэмжээг тогтоох ба ашиглалтын тайлан мэдээг гаргах ажилд эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан усны тоолуурын заалтыг үндэслэнэ. |
| 5 | Байгаль орчинд халгүй, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуй нэгж байгууллагыг урамшуулах журам. <i>Байгаль орчныг хамгаалах тухай хууль"- ийн 19 дүгээр зүйлийн 5 дугаар заалтын дагуу Засгийн газрын 1998 оны 95 дугаар тогтоолоор батлагдсан ба Засгийн газрын 2017 оны 290 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан.</i> | Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөлөл, бохирдлыг багасгахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж, байгаль орчинд халгүй, хоргүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи /цаашид "халгүй технологи" гэнэ/ нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулахад энэ журмыг дагаж мөрдөнө. Байгаль орчинд халгүй технологи гэдэгт хүрээлэн байгаа орчин, хүний эрүүл мэндэд сөрөг үр дагавар учруулахгүй, орчиндоо хоргүй, бохирдол багатай, хаягдалгүй байх чадвартай үйлдвэрлэл, үйлчилгээний бүхий л төрөл, хэлбэр хамаарна. |
| 6 | Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам. <i>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 01-р сарын 27-ны өдрийн 21-р тушаалын 1 дүгээр хавсралт</i> | Хог хаягдлын тоо бүртгэлийг хөтөлж, нэгтгэн боловсруулах, тайлагнах, албан ёсны статистик мэдээллийг бүрдүүлэхтэй холбогдсон төрийн захиргаа, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хоорондын харилцааг зохицуулдаг журам бөгөөд энэхүү журмын дагуу батлагдсан маягт болон “эх үүсвэрээс гарах хог хаягдлын хор аюулын зэрэглэлээр кодчилсон жагсаалт”- ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, энэ журмаар тогтоосон хугацаанд тайлангаа сум дүүргийн Засаг дарга эсхүл түүний томилсон этгээдэд гаргаж өгнө. |

| | | |
|----|--|---|
| 7 | Аюултай хаягдлын хадгалалт, устгалын бүртгэл хөтлөх, мэдээ гаргах заавар <i>Байгаль орчны сайдын 2003 оны 127 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт батлагдсан.</i> | Аюултай хаягдал гаргагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь аюултай хаягдлын хадгалалт, устгалын тайланг сум, дүүргийн Засаг даргад жил бүрийн 11 дүгээрсарын 15-ны дотор хүргүүлнэ. |
| 8 | Агаарын чанарын мэдээлэл гаргах журам <i>БОАЖЯ сайдын 2018 оны 07-р сарын 04- ний өдрийн А/222 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан.</i> | Агаарын тухай хуулийн 9.1.4-д зааснаар аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу дотоод хяналтыг явуулах үүрэгтэй. Түүнээс гадна аж ахуйн нэгж байгууллага нь агаарын бохирдлын эх үүсвэрийн дотоод хяналтын болон холбогдох бусад тайлан, мэдээг мэргэжлийн албаны орон нутаг дахь салбарт гаргаж өгөх ёстой (Агаарын тухай хуулийн 9.1.5). |
| 9 | Аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналт шалгалтын журам. Энэ журмыг Монгол улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 311 дугаар тогтоолын хавсралтаар баталсан. | 3.7.11-р дугаар заалтад дотоод хяналт шалгалтаар хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн буй орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авч, эрх бүхий байгууллагад мэдэгдэх шаардлагатай хэмээн тусгасан байдаг. Түүнчлэн 4.1.2-д аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд хяналт шалгалт хийхээр заажээ. |
| 10 | Энгийн хог хаягдлыг цэвэрлэх ангилах цуглуулах тээвэрлэх дахин боловсруулах сэргээн ашиглах устгах булшлах журам. <i>Уг журмыг Өмнөговь аймгийн 2019 оны 12 сарын 4 өдрийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор баталсан.</i> | Энэхүү журмын 3.2.1-т Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үүсгэж буй энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь болон үйл ажиллагааны явцад “дахин ашиглах, үнс, бусад” гэсэнтөрлөөр ангилж эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хүлээлгэн өгнө гэж заасан байна. |
| 11 | Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам <i>Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 48 дугаар тушаалын хавсралт</i> | Тус журмын 2.2-т Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үүсгэж буй барилгын хог хаягдлаа эх үүсвэр дээр нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх шинж чанараар тодорхойлж Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дүгээр тушаалаар батлагдсан Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн “аюултай”, “хяналттай”, “энгийн” зэрэглэлд хамрагдсанаар нь ангилан ялгахаар заажээ. |

БҮЛЭГ №1 ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1.1 Төслийн нэр:

“Ажилчдын хотхон, авто зогсоол байгуулах” төсөл

1.1.2 Төсөл хэрэгжүүлэгч:


- ✓ Байгууллагын нэр: “Цагаан дэлгэрэх өргөө” ХХК
- ✓ Улсын бүртгэлийн дугаар: 1111016251
- ✓ Регистрийн дугаар: 3641856
- ✓ Хаяг: Өмнөговь аймаг, Цогтцэций сум, 3-р баг, Цагаан-Овоо, 2-р өргөлтийн насосын зүүн талд, ажилчдын хотхон 104 тоот
- ✓ Утас: 88105328

1.1.3 Төслийн талбайн байршил, хэрэгжих орчны тойм зураг

Ажилчдын хотхон, авто зогсоол нь Улаанбаатар хотоос 760 км зайд, Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон-1 баг, Цагаан хадны нутаг дэвсгэрт байрлана. Уг төсөл нь нийт 20,5 га газарт хэрэгжих ба 8 га болон 5 га газарт ажилчдын хотхон, 7,5 га газарт авто зогсоол, цэвэрлэх байгууламж байгуулахаар төлөвлөж байна. “Цагаан дэлгэрэх өргөө” ХХК нь “Эрхэт Түнш” ХХК-тай хамтран ажиллах гэрээний дагуу тус тус 12,5 га газрыг цэвэрлэх байгууламж үйл ажиллагаа явуулж байна.

Дугаар 4 болон дугаар 10 хавсралтуудаас дээрх 2 байгууллагатай хийсэн түрээсийн гэрээг үзнэ үү.

| Талбайн эзэмшигч | Зориулалт | Цэг | Өргөрөг | Уртраг | Урт |
|-----------------------------|----------------------------------|-----|-------------|------------|--------|
| “Цагаан дэлгэрэх өргөө” ХХК | Үйлдвэрлэлийн барилга байгууламж | 1 | 4725112.111 | 703653.979 | 158.23 |
| | | 2 | 4725212.666 | 703531.812 | 316.15 |
| | | 3 | 4725456.764 | 703732.728 | 158.23 |
| | | 4 | 4725355.977 | 703854.704 | 315.85 |
| “Эрхэт түнш” ХХК | Кемп, авто засвар зогсоол | 1 | 4725198.09 | 704035.52 | 250.01 |
| | | 2 | 4725362.52 | 703847.21 | 200.07 |
| | | 3 | 4725753.161 | 703978.580 | 406.68 |
| | | 4 | 4725490.762 | 704289.280 | 387.36 |



Зураг 1. Төслийн талбайн байршил


1.2 ХОТХОНЫ ТӨЛӨВЛӨЛТ

Ажилчдын хотхон, авто зогсоол байгуулах төслийн талбай нь 2 хэсгээс бүрдэнэ. Эрхэт Түнш ХХК-тай хамтран гэрээний хүрээнд 12,5 га газар хоногт 180м³ ахуйн гаралтай бохир ус хүлээн авч биологийн аргаар цэвэрлэж, цэвэрлэгдсэн бохир усыг ууршуулах талбайд нийлүүлэх хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламж байгуулан бүрэн хүчин чадаар ашиглаж байгаа бөгөөд үлдсэн га газарт авто зогсоол байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Өөрийн эзэмшлийн 8 га газарт кемпийн гал тогоо, хувцас угаалгын барилга, уурын зуух болон байрлагчдын амрах байр 3 блок барилга зэрэг ажилчдын хотхоны үндсэн байгууламжууд байрлана.

Ажилчдын хотхон нь нийт 1034 хүн хүлээн авах хүчин чадалтай байна. Үүнд:

- ✓ А амрах байр - 61 өрөө * 4 хүн
- ✓ В амрах байр – 105 өрөө * 4 хүн
- ✓ С амрах байр – 105 өрөө * 4 хүн



Зураг 2. Ажилчдын хотхоны ерөнхий төлөвлөлтийн зураг

1.3 ХҮЧИН ЧАДАЛ, БАГТААМЖ

Тус төсөл нь нэг зэрэг 1034 хүнийг хүлээн авах хүчин чадал бүхий 3 блок барилгаас бүрдэнэ. Ажилчдын хотхон нь Цагаан хад суурьшлын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа тээврийн компаниудын ажилтнуудыг байрлах байр, стандартын шаардлага хангасан нөхцөлд эрүүл аюулгүй хоол хүнсээр үйлчилж, тав тухтай байдлыг ханган ажиллах болно.

Хүснэгт 5. Ажилчдын хотхоны ажиллах хүчний үзүүлэлт

| Д/д | Үзүүлэлт | Дүн |
|-----|------------------------|--------|
| 1 | Ажилчдын тоо | 100 |
| 2 | Ээлжийн тоо | 2 |
| 3 | Жилд ажиллах өдөр | 365 |
| 4 | Жилд ажиллах цаг | 4380 |
| 5 | Сард ажиллах өдөр | 14(15) |
| 6 | Сард ажиллах цаг | 360 |
| 7 | Өдөрт ажиллах нийт цаг | 12 |

1.4 ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ

“Цагаан Дэлгэрэх Өргөө” ХХК-ийн захиалгаар “Хаанзаа Сервисес” ХХК нь хоногт 180 м³ ахуйн гаралтай бохир ус цэвэрлэх хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламж байгуулан ажиллаж байна.

Уг цэвэрлэх байгууламж нь бохир ус хүлээн авах байгууламж, өргөх худаг, 2 ширхэг ууршуулах талбай болон лагийн талбайгаас бүрдсэн цогц байгууламж бөгөөд ахуйн бохир усыг биологийн аргаар цэвэрлэж, цэвэрлэгдсэн бохир усыг ууршуулах талбайд нийлүүлэхээр төлөвлөгдсөн.

Цэвэрлэгдсэн усны чанарт өдөр тутмын хяналт хийгдэх ба цэвэрлэгдэж гарсан усны дээжийг сард нэг удаа итгэмжлэгдсэн лабораториор хянуулж, дүгнэлт гаргуулан ажиллаж байна. Цэвэрлэгдсэн усны цэвэрлэгээний төвшин Монгол улсын стандарт MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлагад нийцсэн байна.

Цэвэрлэх байгууламж доголдол гарсан үед түр ашиглах хуримтлуулах 1 ширхэг ёмкост суурилуулсан ба хуримтлагдсан лаг болон саарал усаа бохир соруулах зориулалтын машинаар соруулан “Ханбогд вейст менежмент” ХХК-тай хийсэн гэрээний дагуу нийлүүлнэ.

1.5 ДЭД БҮТЭЦ

Цахилгаан болон дулаан хангамж

Ажилчдын хотхон нь “Цагаан хад” эрчим хүчний Дэд төвөөс эрчим хүчний эх үүсвэрээр хангагдана. Нийт 14 км үргэлжлэх 166 цэгт 10кВ агаарын цахилгаан дамжуулах шугам сүлжээгээр тоноглогдсон ба ажилчдын хотхоны дэргэд байрлах 400кВА, 630кВА гэсэн 2 комплект трансформатораар тоноглогдон эрчим хүчний хэрэглэгчээ бүрэн хангадаг.

Байгалийн давагдашгүй хүчин зүйл цас, бороо, хүчтэй салхи шуурга, үер ус болон байнгын эрчим хүч түр хугацаагаар тасарсан үед 200кW, 250 кW-ийн дизель генераторуудыг нөөцөд бэлэн байдал хангуулан ажилладаг бөгөөд нөөцөд байх түлшний хэмжээ 400 литр байдаг.

Цагаан дэлгэрэх өргөө ХХК-ийн ажилчдын хотхон нь нэг ээлжинд 1000 гаруй хүн хүлээн авах хүчин чадалтай бөгөөд ажилчдын хотхоныг усан халаалтын уурын зуухны ерөнхий төлөвлөгөөний зураг төслүүдийг үндэслэн БНБД 41-02-13 дулааны сүлжээ, БНБД 41-03-13 тоног төхөөрөмж дамжуулах хоолой, дулаан тусгаарлалтын холбогдох норм дүрмүүдийг баримтлан хийж гүйцэтгэсэн.

Уурын зууханд 1 мВт – 1 зуух, 0.6кВт - 1 зуух дулаан болон хэрэглээний халуун, хүйтэн усаар хангах дулаан дамжуулах сүлжээний насосуудаар тоноглогдсон байна. Гадна агаарын температур хасах 20.5°C байхад дулааны сүлжээний өгөх хэм +90°C, буцах хэм +70°C байдаг. Ялтсан бойлероор дамжин гарах хэрэглээний халуун усны хэм +50°C байхаар дундажлан ажилчдын хотхонд нийлүүлдэг.

Уурын зуухны тоног төхөөрөмж, тоноглолууд болон гадна гэрэлтүүлэгүүд нь байнгын цахилгаан эрчим хүчээр хангагдсан. Цахилгаан хүчдэл тасрах үед 200кW дизель генератораар цахилгаан хангамжаар давхар хангагдана.

Усан хангамж

2021 онд Ханбогд сумын Номгон багийн нутаг, уртраг N 42°45', 953", өргөрөг E 107°22'948"-г өрөмдлөг хийж, худаг гаргах зөвшөөрөл авч “Эхний эхэн” ХХК-тай гэрээ байгуулан цооног өрөмдүүлж гүний худаг гарсан. Тус гүний худгийг паспортжуулан, Ханбогд сумын Засаг даргатай байгуулсан 2022/04 дугаар бүхий “Ус ашиглах гэрээ”-г үндэслэн хоногт 34.5 шоо метр усыг унд ахуйн зориулалтаар ашиглах “Эрхийн бичиг” нэг жилийн хугацаатай авсан.

Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 05 тоот дүгнэлт, Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” А/22 тоот тушаал, мөн өдрийн ӨМБОАЖГ-2023/29 дугаар бүхий “Ус ашиглах гэрээ”-г үндэслэн кемпийн ахуйн хэрэглээний усны хэрэгцээг ханган ажиллаж байна.

Ус ашиглалт

Ажилчдын хотхонд бүрэн хүчин чадлаараа ажиллахад нэг хүний өдөрт гаргах ахуйн хаягдлын хэмжээг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12-р хавсралтаар батлагдсан орон сууц нийтийн байр, гэр хорооллын усны хэрэглээний нормыг үндэслэн Ажилчдын хотхонд амрах нэг хүний усны хэрэглээний нормыг 45 литрээр тооцвол нийт 1034 байрлагчийн унд ахуйн хэрэгцээний усны хэмжээг доор үзүүлснээр тооцлоо. Үүнд:

Хоногт: 1034 хүн*45л= 46,5300 л буюу 46,53 м³

Сард: 46.53 м³*31 хоног=1,442.43 м³

Жилд: 1,442.43 м³*12 сар= 17,309.16 м³ ус хэрэглэхээр байна.

1.6 ХОГ ХАЯГДАЛ

Цагаан дэлгэрэх өргөө ХХК-ийн Ажилчдын хотхон, авто зогсоол байгуулах төсөл нь нэг зэрэг 1084 хүнийг хүлээн авах хүчин чадал бүхий 3 блок барилга байхаар төсөлд тусгасан. Иймд тус хотхонд нэг дор 1084 хүн байрлах боломжтой байна.

Хатуу хог хаягдал

Ажилчдын хотхонд бүрэн хүчин чадлаараа ажиллавал дээд тал нь 1084 хүн байрлахаар байгаа бөгөөд нэг хүний өдөрт гаргах ахуйн хаягдлын хэмжээг 0.5 кг гэж тооцвол:

Хоногт: $1034 * 0.5 \text{ кг} = 517 \text{ кг}$ хог хаягдал

Сард: $517 \text{ кг} * 31 = 16,027 \text{ кг}$ буюу 16.02 тонн

Жилд: $517 \text{ кг} * 365 = 188,705 \text{ кг}$ буюу 188.7 тонн хатуу хог хаягдал гаргахаар байна.

Кемпийн хог хаягдлын цэгийг салхины зонхилох чиглэлийн доор Ханбогд сумын Байгал орчны байцаагчийн тогтоосон цэгт байгуулж, байрлагч болон нэгж салбарын хогийг өдөр бүр цуглуулан эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн хадгалж, “Ханбогд хот тохижилт” ОНӨААТҮГ-тай байгуулсан “Хог тээвэрлэлтийн гэрээ”-ний дагуу 10 хоног тутамд зайлуулж, ариутгал халдваргүйтгэл хийж хэвшсэн.

Компанийн зүгээс байрлагчид болон үйлчилгээний явцад үүсэх хатуу хог хаягдлын хэмжээг багасгахын тулд анхан шатны ангилан ялгалт хийж, байгаль орчинд үзүүлэх хор нөлөөг бууруулах чиглэлийг баримтлан цаашид дахин боловсруулах, дахин ашиглах чиглэлд илүү анхаарч ажиллах төлөвлөгөөтэй байна.

Ахуйн шингэн хог хаягдал

БОНХАЖ Сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А-301 дугаарт тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 12 дугаар хавсралт Орон сууц нийтийн байр, гэр хорооллын усны хэрэглээний нормыг үндэслэн Ажилчдын хотхоны хоног, сар, жилийн хэрэглээний усыг өмнөх хэсэгт тооцоолсон билээ. Тооцоолсон усны хэрэглээний 90 хувь нь ахуйн шингэн хаягдал болно гэж үзвэл доорх хүснэгтэд үзүүлсэн хэмжээний шингэн хаягдал гарахаар байна.

Хүснэгт 6. Шингэн хаягдлын тооцоо

| Зарцуулах цэвэр усны хэмжээ, м ³ | | Үүсэх шингэн хаягдлын хэмжээ, м ³ |
|---|-----------|--|
| Хоногт | 46.53 | 46.53 |
| Сард | 1.442.43 | 1.442.43 |
| Жилд | 17.309.16 | 17.309.16 |

Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж нь хоногт 180м³ бохир усыг биологийн аргаар цэвэршүүлэх хүчин чадалтай. Цэвэрлэгдсэн усны цэвэрлэгээний төвшин “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 4943:2015 стандартад нийцэж байна.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 ФИЗИК ГАЗАРЗҮЙ

Төсөл хэрэгжих бүс нутгийн газар зүйн байршлын хувьд Монголын говь цөлийн бүсийн өмнөд хэсэгт байрладаг ба Ханбогд уулын орчимд орших говийн намхан толгодоос тогтох жинхэнэ цөлийн байгалийн бүс, бүслүүрт багтана.

Төсөл хэрэгжих нутаг нь Монгол орны өмнөд цөлийн бүсэд орших бөгөөд энэхүү бүс нь далайн түвшнээс дээш 1000 гаруй метрийн өндөрт өргөгдсөн нам, үргэлжилсэн дов толгодтой тал газар бөгөөд Говийн жижиг (15- 50 метр) толгод болон (далайн түвшнээс дээш 1350 метрийн өндөрт орших Ханбогд уул) өндөр уулсаас тогтдог.

Газарзүйн байршлын хувьд Ханбогд сум нь Монголын говь цөлийн бүсийн өмнөд хэсэгт байрладаг ба Ханбогд уулын орчимд орших говийн намхан толгодоос тогтдог. Тухайн сум нь говийн бүсэд харьцангуй өндөрт тооцогдох уулстай ба үүнд Ханбогд уул (д.т.д 1350 м), Бумбат задгайн хяр (д.т.д 1233.3 м), Жавхлант уул 1295 м (д.т.д), Далайн Дуулга (д.т.д 1266 м) зэрэг уулс орно.

2.2 УУР АМЬСГАЛ

Тус төслийн талбай орчмын газар нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд хавар, намартаа сэрүүн, зундаа халуун, өвөлдөө хүйтэн байдаг. Хавартаа маш хуурай бөгөөд салхи, шуурга ихтэй байна. Бүс нутгийн жилийн дундаж агаарын температур 8.18°C, үнэмлэхүй их температурын дундаж 22.88°C, үнэмлэхүй бага температурын дундаж -6.33°C байна.

Агаарын сарын үнэмлэхүй их, бага температурын олон жилийн дундаж хэмжээ нь тухайн орон нутаг дахь боломжит хязгаарыг илтгэдэг. 2008-2020 оны Ханбогд сумын цаг уурын станцын ажиглалтын мэдээгээр сарын дундаж температурын хамгийн бага утга нь -17.2°C (2011.01), сарын дундаж температурын хамгийн их утга нь 27.9°C (2010.07) хүрсэн байна. Агаарын дундаж температур 8.18°C байна.

2.3 ГАДАРГЫН УС

Өмнөговь аймгийн Ханбогд сум нь Төв Азийн гадагш урсацгүй ай савын өмнөд мужид байрладаг бөгөөд Монголын хамгийн том ус хураах ай савд багтдаг хаалттай буюу гадагш урсгалгүй ай сав юм. Мөн Монгол орны баруун хойд хэсэгт байрлах Их нууруудын хотгор, Монгол улсын өмнөд хэсэг болон БНХАУ-ын хойд хэсэг орчмын гадаргуун урсацаас тогтсон нуурууд зэрэг багтана.

2.4 ХӨРСӨН БҮРХЭВЧ

Цагаан дэлгэрэх өргөө ХХК-ийн Ажилчдын хотхон, авто зогсоол байгуулах төсөл хэрэгжих Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг нь хөрс-газарзүйн мужлалын Төв Азийн их мужийн говийн мужийн өргөргийн бүсшилийн хээржүү цөлийн бор хөрсний 8-р тойрогт багтана. Төсөл хэрэгжих талбай нь ухаа толгод хоорондын өргөн хөндийд байрлах ба талбайн 2 талаар Гашуун сухайт боомт чиглэлийн замууд өнгөрдөг. Тэгшивтэр тал газрын заримдаг цөлийн ургамалшил дор сул хөгжилтэй элсэрхэг говь цөлийн бор хөрс тогтворжсон байдаг онцлогтой.

Төслийн талбайн хөрсний химийн ерөнхий шинжилгээний үр дүнгээс харахад шүлтлэг урвалын орчинтой, бага зэрэг карбонаттай, ялзмагийн агууламжаар бага зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар бага, механик бүрэлдэхүүн элсэнцэр. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага байна.

Өнөөгийн байдлаар тус бүс нутагт хүний үйл ажиллагаатай холбоотойгоор буюу тээврийн зам, гаалийн хяналтын бүс, эдгээрийн амьдрах байр, үйлчилгээний газруудын үйл ажиллагаанаас үүсэх хөрсний элэгдэл, эвдрэл, доройтол өргөн цар хүрээтэйгээр бий болж болзошгүй байна. Тухайлбал, тээврийн хэрэгсэл хатуу хучилттай замаас гарч шороон замаар явж, олон салаа зам үүсгэснээс хөрсний чийг, тогтворжилтыг бууруулж, ургамлан нөмрөгийг талхлах, хомсдох эрсдэлтэй байна.

2.5 УРГАМЛАН НӨМРӨГ

Төсөл хэрэгжих талбай нь Монгол орны Ургамал-Газарзүйн мужлалаар Алашаа говийн (цөлийн) тойрогт багтана. Алашаа говийн (цөлийн) тойрог: Энэ тойрогт Монголын говь, Зүүнгарын умард говийн зүйлүүд зонхилох бөгөөд баян бүрдийн ургамлууд, Казакстан-Тураны зүйлүүд ч байдаг. Тухайн тойрогт тохиолдох 13 зүйл ургамал байна.

2.6 АМЬТНЫ АЙМАГ

Төслийн талбай орчим нь Монгол орны хөхтөн амьтдын тархцын мужлалаар Алтайн өвөр говийн тойрогт хамаарагдаж байна. Төслийн талбай нь говийн нам уулс, толгод хоорондын хөндий хотос газарт байрлана. Төслийн талбай орчимд нөлөөлөл үүсгэж байгаа Цагаан хадны суурин, тээврийн хөдөлгөөн, хатуу хучилттай зам зэргийн нөлөөгөөр амьтдын амьдрах орчин хуваагдаж, амьтдын тархац нутаг хумигдсан бөгөөд тус төслийн талбай орчимд томоохон хөхтөн амьтад (хар сүүлт, махчин амьтад)-ын тохиолдоц байхгүй. Харин жижиг хөхтөн амьтад болох чичүүл, алаг даага зэрэг тохиолдоно. Мөн талбай орчимд шувуудаас хээрийн бор шувуу *Passer montanus*, хон хэрээ *Corvus corax*, шоорон эвэрт болжмор *Eremophila alpestris* зэрэг шувууд тохиолдоно.

2.7 НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГ

Өмнөговь аймгийн Ханбогд сум нь 1924 онд Галба сум нэртэйгээр Хадан хошуу гэх газарт анх үүсгэн байгуулагдсан түүхтэй. Үүнээс хойш олон удаа нүүдэллэж 1941 онд одоогийн Их булаг хэмээх газарт суурьшиж хөгжсөөр байна.

Ханбогд сум нь зүүн талаараа Дорноговь аймаг, баруун талаараа Номгон, хойд талаараа Манлай сумдтай хиллэх бол сумын урд хил нь Хятад улстай хиллэдэг. Жавхлант, Гавилууд, Номгон, Баян, болоод Хайрхан гэсэн аж ахуйн 5 багтай. 2019 оны байдлаар Ханбогд суманд нийт 8660 хүн оршин

сууж байна.

2018 онд Ханбогд сум нь нийт 622 малчин, 380 малчин өрх нийт 165530 тоо толгой малтай байсан бол 2019 онд эдгээр үзүүлэлтүүдээс малчдын тоо 573 болж буурсан ч малчин өрхийн хэвээр байгаа үзүүлэлттэй байна.

Ханбогд суманд 2019 оны байдлаар нийт 190030 малтай бөгөөд үүнд ямаа 91160, хонь 51980, тэмээ 31160, адуу 9280, үхэр 5950 байна. Доорх графикт уг сумын багуудад малын тоо толгой хэчнээн байгааг харуулсан бөгөөд Гавилууд баг малын тоо толгойгоор тэргүүлж, Хайрхан багт малын тоо толгой хамгийн бага байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Цагаан дэлгэрэх өргөө” ХХК-ийн “Ажилчдын хотхон, авто зогсоол байгуулах” төслийн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчин, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй сөрөг нөлөөллийн хураангуйг доорх хүснэгтэд тоймлон үзүүлэв.

Хүснэгт 3-1. Хүнд даацын автомашины ээлж солилцох зогсоолын талбай төслийн байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл

| № | Нөлөөллийн төрөл | Нөлөөллийн эх үүсвэр /үйл ажиллагаа/ | Нөлөөллийн шинж чанар |
|--|--|--|--|
| <i>Агаар</i> | | | |
| 1 | Агаар бохирдох, агаарын чанар муудах | Тээврийн хэрэгсэл болон байрлагчдын хөл хөдөлгөөн ихсэх | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэмэгдсэнээр яндангаас ялгарах хорт хий болон тоосжилтын улмаас агаар бохирдох |
| 2 | | Халаалт, дулааны системд уурын зуух ашиглах | Уурын зуух ашиглах явцад үүсэх утаа тортоогоор агаар бохирдох |
| <i>Газрын гадарга болон хөрсөн бүрхэвч</i> | | | |
| 1 | Хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэлд өртөх | Тээврийн хэрэгсэл, байрлагчдын хөл хөдөлгөөн ихсэх | Ажилчдын хотхон тээврийн хэрэгсэл, байрлагчдын хөл хөдөлгөөний нөлөөгөөр хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэх |
| 2 | | Цэвэрлэх байгууламжид гэмтэл гарсны улмаас бохир ус асгарч хөрсний бохирдол үүсгэх | Цэвэрлэх байгууламжид гэмтэл гарах, хүйтний улиралд шугам хоолой хөлдөж хагарах зэргээс үүдэн бохир усыг хөрсөнд алдаж хөрс бохирдох |
| 3 | | Ахуйн хатуу, шингэн хог хаягдлын битүүмжлэл алдагдах | Ахуйн хатуу шингэн хог хаягдлын битүүмжлэл алдагдаж хөрсийг бохирдуулах |
| <i>Усны нөөц</i> | | | |
| 1 | Усны нөөцийн хомсдол | Төслийн талбай орчимд хүн амын бөөгнөрлөөс хамаарч газрын доорх усны нөөцийн хомсдол цэгэн шинжтэй илрэх болсон ¹ | Усыг хяналтгүй ашигласан тохиолдолд газрын доорх усны нөөц хомсдох |
| <i>Ургамалан нөмрөг</i> | | | |
| 1 | Ургамалан нөмрөгийн талхлагдал, доройтол | Тээврийн хэрэгсэл, байрлагчдын хөл хөдөлгөөн ихсэж, ургамалан нөмрөг талхлагдах | Байрлагчид болон тээврийн хэрэгслийн хөл хөдөлгөөний нөлөөгөөр газрын хөрс доройтох |

| | | | |
|-------------------------|---|--|---|
| 2 | | Ахуйн болон техник хэрэгслээс үүсэх хог хаягдал | Салхи шуурга болон үерийн усаар хог хаягдал талбайд тархаж ургамлан нөмрөгийг доройтуулах |
| <i>Амьтны аймаг</i> | | | |
| 1 | Ан амьтан үргэж дүрвэх | Төслийн талбайн болон ойр орчмын нүүдэллэгч амьтад хүний хөл хөдөлгөөнөөс дайжих | Ан амьтад дайжих, алга болох Үүнд: Говийн хулан, хар сүүлт зэрэг нүүдэллэгч амьтад багтаж байна. |
| <i>Хүний эрүүл мэнд</i> | | | |
| 1 | Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангаагүйгээс халдвартай болон халдваргүй өвчин гарах | Агаарын чанар стандартын шаардлага хангахгүй байх буюу нарийн болон бүдүүн ширхэглэгт тоосонцор их байх үед хариу арга хэмжээ аваагүй тохиолдолд | Шаардлага хангахгүй бохирдсон агаартай нөхцөлд урт болон богино хугацаагаар өртөх нь амьсгалын зам үрэвсэх, зүрх судасны өвчлөлд өртөх, уушгины хавдар тусахад хүргэж болно |
| 2 | | Чанарын шаардлага хангаагүй ус хэрэглэх буюу усыг цэвэршүүлэхгүй хэрэглэх үед | Хоол боловсруулах замын элдэв төрлийн халдварт өвчлөлд хүргэж болно. |
| 3 | | Байрлагчдын хэрэглэх хоол ундны болон цагаан хэрэглэл, ариун цэврийн өрөө зэргийг хангалттай ариутгаагүй үед | Энэ нь байрлагчдын дунд халдвартай болон халдваргүй өвчин дамжин тархах нөхцөлийг бүрдүүлэх |

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Зорилго, зорилт: “Цагаан дэлгэрэх өргөө” ХХК-ийн Ажилчдын хотхон, авто зогсоол байгуулах төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29–ний өдрийн А- 618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

Баримтлах зарчим: Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11 сарын 1-ний дотор Ханбогд сумын ЗДТГ-т танилцуулан, 12 дугаар сарын 31-нд багтаан Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 3-аас доошгүй хувь хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраар батлуулах үүрэгтэй.

Төсөл хэрэгжүүлэгч “Цагаан дэлгэрэх өргөө” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, Ханбогд сумын нөхөн сэргээлтийн тусгай дансанд төслийн үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ.

Хэрвээ “Цагаан дэлгэрэх өргөө” ХХК байгаль хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж, жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлсэн бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3-т заасан хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн мөн хуулийн 9.10-т зааснаар хуримтлагдсан хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу буцаан олгохоор зохицуулагдсан.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй:

Ажилчдын хотхон, авто зогсоол байгуулах төслийг хэрэгжүүлэгч “Цагаан дэлгэрэх өргөө” ХХК нь байгаль орчныг хамгаалахад шаардагдах төсөв хөрөнгийг жил бүр нарийвчлан тооцон, тухайн жилийн төсөвт багтаан, зохих хэлбэрээр зарцуулах үүрэгтэй. БОМТ-г хэрэгжүүлэх 2024 оны дундаж зардлыг 33.176.500 ₮ буюу гучин гурван сая нэг зуун далан зургаан мянга таван зуун төгрөг байхаар тооцлоо. Төслийн БОМТ хэрэгжүүлэх 2024 онд дундаж зардлуудын хураангуйг доор харуулав.

Хүснэгт 4-1. БОМТ-г хэрэгжүүлэх зардал 2024 он

| № | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө | Нийт зардал сая |
|--------------------|---|-------------------|
| 1 | Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө | 5.457.0 ₮ |
| | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 16.997.2 ₮ |
| | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 1.740.0₮ |
| | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 9.900.0₮ |
| | Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө | 1.000.0₮ |
| | | 300.0 |
| Нийт зардал | | 35.394.200 |

4.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчин буюу агаар, ус, хөрс, ургамлан нөмрөг болон амьтны аймагт үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах, арилгах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн авч үзсэнийг Хүснэгт 4-2-т бүрэн эхээр харуулав. Энэхүү төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, тэдгээрийг бууруулах, арилгах бүрэн боломжтой.

Хүснэгт 4-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Нэгжийн зардал сая | Нийт зардал (2024) | Хэрэгжүүлэх давтамж, хугацаа | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|--|---|---|---------------------------------|--------------------|--|------------------------------|---|
| <i>Агаарын чанар</i> | | | | | | | |
| 1. | Халаалтыг уурын зуух ашиглан шийдвэрлэх тохиолдолд нүүрсээр утаа тортог үүсгэгч шатамхай түлш ашигласнаар агаар бохирдоно | Нүүрсний шаталтаас үүссэн утаа тортогийг зуухны арын хэсэгт байрлах утаа хуйлруулан барих камерт өндөр температурт тортоггүйжүүлэх, зуухны их цэвэрлэгээг тогтмол хийснээр агаарт хаягдах тоос, хорт хийг бууруулах | Төслийн уурын зууханд | | Дотоод төлөвлөлтөөр Ашиглалтын заавар зөвлөмжид заасны дагуу | 2024 онд | MNS ISO 4227:2002 MNS 6063:2010 MNS 5885:2008 MNS 4990:2016 MNS 6757 : 2019 |
| 2. | Автомашин хөдөлгөөн, замын ачааллаас үүсэх тоосоор агаар бохирдоно. | Орчны тоосжилтыг бууруулах зорилгоор зам дагуу усалгаа хийх, кемп дотор автомашин 20 км/ц хурдтай явах замын тэмдэг тэмдэглэгээг байрлуулж чанд мөрдүүлж ажилласнаар бохирдлыг бууруулна. | Төслийн талбайд | | Дотоод төлөвлөлтөөр | 2024 онд | MNS 4585:2018 |
| <i>Хөрсөн бүрхэвч (газрын гадарга)</i> | | | | | | | |
| 1 | Төслийн талбайд хөрс хуулалт, хашаа, суваг шуудуу байгуулах зэрэг газар шорооны ажил явагдсан хэсгүүдэд нөхөн сэргээлт хийх | Байрлагчдын амрах байр орчимд мод бут тарьж, зүлэгжүүлэн ногоон байгууламж байгуулна. | Төслийн талбайн 50% хамрагдана. | | 2.500.0 мян.төг | 2024 онд | MNS 5916:2008 MNS 4919:2000 MNS 5918:2008 |

| | | | | | | | |
|------------------|---|---|--|----------------------|-----------------------------------|--|---|
| 2 | Ажилчдын хотхоны зам талбайн хөрсөн бүрхэвч тээврийн хэрэгсэл, хүний хөл хөдөлгөөний явцад элэгдэх, эвдрэх | Ажилчдын ажилдаа явах, үйлчилгээний цэгүүдэд ирж очих зам болон автомашины замыг цардаж, хөрсний эвдрэл гэмтлээс хамгаална. | Барилга байгууламж бүхий хэсгүүдэд | Дотоод төлөвлөл төөр | Үйл ажиллагааны Зардалд тусгасан. | 2024 онд | |
| 3 | Ахуйн хог хаягдлын битүүмжлэл алдагдаж хур тунадас, үерийн усаар ойр орчмын хөрсийг бохирдуулах | Хог хаягдлыг кемпийн нэгдсэн хогийн цэгт зориулалтын саванд цуглуулж, сумын тохижилтын газартай хийсэн гэрээний дагуу зайлуулж, ариутгал халдваргүйтгэл тогтмол хийх | Хогийн цэгт халдваргүйт гэл хийнэ. | Дотоод төлөвлөл төөр | Хог хаягдлын МТ-нд | 7 хоног бүр | Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйл |
| 4 | Аваар ослын үед ашиглах энгийн бие засах газарт цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгал халдваргүйтгэл тогтмол хийж, шавьж, шимэгч үржихээс сэргийлж хөрсний бохирдлоос хамгаалах | Энгийн бие засах газарт цэвэрлэгээ, үйлчилгээ, халдваргүйтгэл 10 хоног тутам хийж, шавьж, шимэгчгүйтгэлийг хавар намрын улиралд тус бүр хийнэ. | Кемпийн хэмжээнд байгаа 2-4 суудал бүхий 2 энгийн бие засах газарт | 739.3 мян төг | 2.957.2 мян. төг | Хавар, намар 10 хоногт, зуны улирал 7 хоног бүрт | Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS 3297:2019 |
| <i>Усны нөөц</i> | | | | | | | |
| 1 | Усыг зөвшөөрөгдсөн нормоос хэтрүүлэн, хяналтгүй ашигласан тохиолдолд газрын доорх усны нөөц хомсдох нөлөөг үзүүлэх | Ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай байгуулах | Төслийн хэрэглээний ус ашиглах явцад | | Үйл ажиллагааны зардалд тусгах | | |
| 3 | Төсөл хэрэгжих нутгийн газрын доорх ус хатуулаг, эрдэсжилт ихтэй байна | Төслийн үйл ажиллагаанд ашиглах худгийн усанд хими, физик, хүнд металлын шинжилгээ хийлгэж, үр дүнгээс нь шалтгаалан усны онцлогт тохирсон ундны усыг зөөлрүүлэх эсвэл цэнгэгжүүлэх төхөөрөмжийг суурилуулж ашиглах | Төслийн ундны усны хэрэгцээнд | | Үйл ажиллагааны зардалд тусгах | 2024 онд | Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам. БОНХЯС -ын 2013 оны А-156 тоот тушаал. MNS EN 12255-10:2012 MNS 0900:2018 |

| | | | | | | |
|---|--|--|---|---|----------|--|
| <i>Ургамалан нөмрөг</i> | | | | | | |
| 1 | Ажилчдын хотхон нь нийт 10 га талбайд хэрэгжих ба тус талбайн ургамлан нөмрөгийн унаган хэв шинж алдагдах, устгах | Байрлагчдын амрах болон ахуйн байрны гадна орчны тохижилт хийж, зам талбайд ногоон байгууламжийн хайлас, улиас, сухай тарих, нөхөн сэргээх, хамгаалах, элэгдэлд орсон талбайг өнгөн хөрсөөр бүрхэж ургамалжуулах | Төслийн талбайд | Уг тайлангийн 5.3.2 Ногоон байгууламжийн төлөвлөгөө хэсэгт тусгагдсан | 2024 онд | MNS 5918:2008 “Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага”. |
| <i>Амьтны аймаг</i> | | | | | | |
| 1 | Төслийн талбай түүний ойр орчимд хог хаягдлыг ил задгай цуглуулснаас мал амьтад тэжээл хайж ирэх орогнох, хордож болзошгүй | Хог хаягдлыг ангилан зориулалтын битүү саванд байршуулах, битүүмжлэлийг байнга хянаж шалгах | Төслийн талбайн хог хаягдлын нэгдсэн цэгт | Хог хаягдлын МТ-нд тусгагдсан | 2024 онд | |
| Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний нийт зардал 5.457.0 мян.төг | | | | | | |

Тайлбар: ТБ – Тодорхойлох боломжгүй

4.2 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Цагаан дэлгэрэх өргөө” ХХК нь Ажилчдын хотхон, авто зогсоол төслийг 2020-2023 онд үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг төслийн 2021-2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд Ногоон байгууламжийг барилга байгууламж барих, дуусгах, хүлээн авч ашиглах үе шат бүрд тохируулан төлөвлөж хэрэгжүүлэхээр заасны дагуу 2022 онд 200 орчим мод бут тарьж, ногоон зурвастай болсон бол 2023 онд 800 гаруй суулгац нэмж суулган, ногоон байгууламж байгуулах ажлаа амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг 2024 онд өргөжүүлэн 2 хэсэгт цэцэрлэгэн хашаа байгуулж, ногоон төгөл ногоон байгууламж бүхий кемп болохоор төлөвлөж байна.

4.3 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ажилчдын хотхон, авто зогсоол байгуулах талбайд ямар нэгэн археологи, палеонтологийн судалгаа хийгээгүй. Гэвч төслийн газар шорооны ажлын явцад соёл өв олдохыг үгүйсгэж болохгүй. Тиймээс үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

Хэрэв барилгын болон үйл ажиллагааны явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд Ажилчдын хотхон, авто зогсоол байгуулах

төслийн үйл ажиллагааг түр зогсоож, холбогдох мэргэжлийн бзахайгууллагаар авран хамгаалах малтлага судалгааг хийлгэх нь зүйтэй.

4.4 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Цагаан дэлгэрэх өргөө” ХХК нь Ажилчдын хотхон, авто зогсоол байгуулах төслийн үйл ажиллагаанаас бий болох хог хаягдлын хэмжээг багасгах, дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах 3R зарчмыг баримтлан ажиллана.

Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, ШТМ асгарсан тохиолдол тухай бүрд нь холбогдох албан тушаалтанд мэдээлэх, хотхоны дотоод журамд хог хаягдлыг ангилах талаар тусган ажиллана. Төсөл хэрэгжих хугацаанд үүссэн хатуу хог хаягдлыг дээрх зөвлөмжийн дагуу зайлуулж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авна.

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Нэгжийн зардал, саятөг | Нийт зардал, төг (2024 он) | Хэрэгжүүлэх хугацаа | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|------|----------------------|---|--|----------------------------------|------------------------------------|---------------------|---|
| 1 | Ахуйн хог хаягдал | Хог хаягдлыг салхин доод талд байршуулсан цоорч гэмтээгүй, шингэн нэвчихгүй, угааж цэвэрлэхэд хялбар, галд тэсвэртэй материалаар хийгдсэн зориулалтын тэмдэг тэмдэглэгээтэй хогийн саванд эх үүсвэр дээр нь ангилан ялгаж төвлөрүүлнэ | Төслийн нийт талбай, ажилчдын байрлах гэр, сууцууд | Үйл ажиллагааны зардалд тусгана | Дотоод төлөвлөлтөөр | 2024 онд | Хог хаягдлын тухай хууль БОАЖЯС-ын 2018.11.17 -ны А/443 тоот тушаал MNS 5344 : 2011 Өмнөговь Аймгийн ИТХ-ын 2019 оны 9/8 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт: |
| 2 | | Ажилчдын хотхоны хогийн нэгдсэн цэгт тогтмол ариутгал, цэвэрлэгээ хийх | Хотхоны нэгдсэн хогийн цэгт | 739.3 мян төг | 2.957.2 | улиралд 1 удаа | “Эрүүл ахуйн тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3.1, 4.4.1 дэх заалт |
| 3 | | ААНБ нь батлагдсан маягт болон “эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, журмаар тогтоосон хугацаанд тайлангаа сумын Засаг даргад хүргүүлэх | “Цагаан дэлгэрэх өргөө” ХХК | Үйл ажиллагааны зардалд тусгана. | Гүйцэтгэгч ажилтны цалинд бодогдох | 2024 онд | |
| 4 | | Байрлагч, ажиллагсдын хэрэглээнээс гарах хог хаягдлыг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэн, тусгай зөвшөөрөл бүхий “Ханбогд хот тохижилт” ОНӨҮГ-тай хийсэн гэрээний дагуу Ханбогд сумын нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэх | Тухайн байршил | 390.0 мян.төг | 14.040.0 мян.төг | Сард 3 удаа | БОНХЯ-ны 2018 оны А/428 дугаар тушаал “Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам” |
| Нийт | | | | | 16.997.2 ₮ | | |

Хүснэгт 3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

4.5 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

“Цагаан дэлгэрэх өргөө” ХХК “Ажилчдын хотхон, авто зогсоол байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгаж хэрэгжүүлнэ.

Хүснэгт 4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгж зардал, төг | Нийт зардал, төг (2023 он) | Тайлбар | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|----------------------|---|--|--------------------|----------------|------------------|----------------------------|------------------------------|---|
| <i>Агаарын чанар</i> | | | | | | | | |
| 1 | Агаар бохирдуулагч нарийн болон том ширхэглэгт тоосонцор (Нийт тоос, PM10, PM2.5) | Амрах байр, авто машины зогсоол орчимд (Нийт 3 цэгт) | Жил бүр | 1 | 54.0 мян.төг | 216.0 мян.төг | Хөндлөнгийн хяналт шинжилгээ | MNS 3113:1981. MNS 4585:2016 MNS 6063: |
| 2 | Агаар бохирдуулагч хий NO2,SO2; | Авто машины зогсоол орчимд (Нэг цэгт) | | | | | | |
| <i>Усан орчин</i> | | | | | | | | |
| 1 | Физик хими, нянгийн бүрэн шинжилгээ, Хүнд металлын шинжилгээ, | Унд ахуйн усны эх үүсвэр | Жил бүр | 2 | 304.0 мян.төг | 608.0 мян.төг | Хөндлөнгийн хяналт шинжилгээ | MNS 4423:1997 MNS 0900:2018 MNS 6778:2019 MNS 5032:2001. |

| | | | | | | | | |
|---|---|---|---------------------|---|----------------|-------------------|------------------------------|---|
| | Хаягдал усны ерөнхий шаардлага стандартад заасан үзүүлэлтүүд | Цэвэршүүлэх байгууламжийн ууршуулах талбайн усанд /3/ | Жил бүр | 2 | 65 мян.т өг | 390.0 мян.төг | Хөндлөнгийн хяналт шинжилгээ | MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин Хаягдал ус.Ерөнхий шаардлага |
| <i>Хөрсөн бүрхэвч</i> | | | | | | | | |
| 1 | Ялзмаг, урвалын орчин (pH), давсжилт, карбонат (CaCO ₃), хөдөлгөөнт кали (K ₂ O), хөдөлгөөнт фосфор (P ₂ O ₅), Шингээгдсэн сууриуд Ca, Mg | Төслийн талбайн доторх хатуу хучилтгүй талбай, хогийн цэг орчимд, ус цэвэрлэх байгууламжийн ууршуулах талбай орчимд, бусад шаардлагатай тохиолдолд байршлыг нэмэх | Жил бүр | 2 | 163.0 мян.т өг | 326.0 мян.төг | Хөндлөнгийн хяналт шинжилгээ | MNS 3297:2019 MNS 4920:2000 MNS 2305:1995 MNS 3298:1991 MNS 5850:2019 |
| 2 | Механик бүрэлдэхүүн, чулуу, чийг, амь чийг, эзлэхүүн жин | | | | | | | |
| 3 | Хар тугалга (Pb), кадмий (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), Мөнгөн ус (Hg), Хүнцэл (As), | Авто зогсоол, хог хаягдлын цэг (Нийт 2 цэгт) | | | | | | |
| <i>Ургамлын аймаг</i> | | | | | | | | |
| 1 | Ургамлын бүрхэц, биомасс, зүйлийн арви тодорхойлох | Талбайн гадна, дотор нөлөөлөлд өртөж болзошгүй цэгүүдэд /4/ | Жилд бүр (6-7 сард) | 1 | 50.0 мян.т өг | 200.0 мян.төг | | Ургамлын бүрхцийг хувиар, биомассыг гр/м ² , зүйлийн арвийг зүйл тус бүрд үнэлэх |
| Орчны хяналт шинжилгээ хийхэд зарцуулагдах урьдчилсан байдлаар тооцсон зардал | | | | | | 1.740.000₮ | | |

4.6 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ажилчдын хотхон, авто зогсоол байгуулах төсөл нь дотоод аюулгүй ажиллагаандаа OHSAS 18001 буюу ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. Осол эрсдэлийн үнэлгээ болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 5. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

| № | Болзошгүй аюул, осол, сөрөгнөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж |
|------|--|---|----------------------------|-------------------|--------------------------------|-----------------|--------------------------------|
| 1 | Аянга цахилгаан | Аянга зайлуулагчийг ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах. Цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг стандартын дагуу газардуулсан байх | Төслийн талбай | Тогтмол | Үйл ажиллагааны зардалд тусгах | | Төслийн хугацаанд |
| 2 | Газар хөдлөлт | Онцгой байдлын журам боловсруулан мөрдөж ажиллах | Төслийн талбай | Тогтмол | | | Төслийн хугацаанд |
| 3 | Шороон шуурга | | Төслийн талбай | Тогтмол | | | Төслийн хугацаанд |
| 4 | Аадар бороо | Үерийн далан шуудууг үргэлжлүүлж, хүмүүст үерийн анхааруулга өгч хүний амь нас, дэд бүтцийг хамгаалах | Төслийн талбай | Жил болгон | | | Төслийн хугацаанд |
| 5 | Үер | | Төслийн талбай | | | | Хур борооны улирлаас өмнө |
| 6 | Халдварт өвчин | Халдварт өвчнөөс хамгаалах хэрэгсэл (амны хаалт, гар ариутгагч г.м) хангалттай нөөцлөх | Төслийн талбай | Нөөц /100 Хүн/ | | | Төслийн хугацаанд, жил бүр |
| 8 | Хөдөлмөр хамгааллын дүрэм зөрчигдөж, ажилтнууд хамгаалах хэрэгслэл бүрэн хэрэглээгүйгээс ажилчдын эрүүл мэнд | Ажилчдад хөдөлмөр хамгааллын сургалт зохион байгуулж, хөдөлмөр хамгааллын дүрмийг мөрдөж ажиллана. | Төслийн ажилчид | Тогтмол | | | Шинээр ажилтан авах бүрд |
| 9 | | Ажиллагсдыг эмнэлгийн үзлэгт хамруулах /урьдчилан сэргийлэх багц үзлэг шинжилгээг хийлгэх/ | Төслийн ажилчид | Нийт ажиллагс дад | 198.0 мян | 9.900.0 сая | Төслийн хугацаанд, жил бүр |
| Нийт | | | | | | | 9.900.000₮ |

4.7 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт 6. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, 5 жилээр

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Хэрэгжүүлэх хуваарь | | | Хариуцсан албан тушаалтан |
|---|---|---------------------------------|------------------------|------------|------------|--|
| | | | 2023 он | | | |
| | | | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал | |
| 1 | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх | Үйл ажиллагааны зардалд тусгах | Төслийн нийт хугацаанд | | | Удирдлага, Байгаль орчны мэргэжилтэн (БОМ) |
| 2 | Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлын талаар мэдлэг олгох, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул, мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаарх сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран жилд 1 удаа зохион байгуулах | 0.5 сая ₮ | Төслийн нийт хугацаанд | | | ХАБ |
| 3 | Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах | Үйл ажиллагааны зардалд тусгах | Төслийн нийт хугацаанд | | | Удирдлага, ХАБ |
| 4 | Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр тогтмол хамруулах. Ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, хордлого тайлах хүнс, бэлдмэлээр хангаж байх | Үйл ажиллагааны зардалд тусгах | Төслийн нийт хугацаанд | | | Удирдлага, ХАБ |
| 5 | Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах | Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан | Төслийн нийт хугацаанд | | | ХАБ |
| 6 | Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ-нд хүргэн өгч байх | Үйл ажиллагааны зардалд тусгах | - | - | 11 сард | БОМ |
| 7 | Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх сургалт, аян, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах | 0.5 сая ₮ | Төслийн нийт хугацаанд | | | БОМ |

| | | | | |
|------|---|-----------|-------------------|----------------|
| 8 | Төслийн эдэлбэр газарт Газрын төлөв байдлын хянан баталгааг хийлгэж, цаашид 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх | 0 | Төслийн хугацаанд | Удирдлага, БОМ |
| Нийт | | 1 000000₮ | | |

4.8 2024 ОНЫ БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч “Цагаан дэлгэрэх өргөө” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайланг хүргүүлэх ба төсөл хэрэгжих Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сумын Засаг даргын тамгын газарт тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ.

Хүснэгт 7. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

| № | БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацааны тов | Тайлагнах зардал, сая төг | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан | Зохион байгуулах газар |
|------|---|---|---|--------------------------------|---------------------------|---|---------------------------|
| 1 | Байгаль Орчин, Аялал Жуулчлалын яам | Тайлангийн эх хувь болон цахим хэлбэрээр албан бичгийн хамт | Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үрдүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна | 11 дүгээр сарын 30-ний дотор | 0.3 сая ₮ | Удирдлага болон Байгаль орчны мэргэжилтэн | Улаанбаатар хот |
| 2 | Өмнөговь аймгийн байгаль орчны газар | | | 11 дүгээр сарын 01-ээс өмнө | | | Өмнөговь аймаг |
| 3 | Ханбогд сумын Номгон багийн Иргэдийн нийтийн хуралд | Илтгэл байдлаар хэлэлцүүлэх | | 11 дүгээр сарын 01-ээс өмнө | | | Ханбогд сумын Номгон багт |
| Нийт | | | | 300.000 ₮ | | | |